


## 2026 ОНЫ II УЛИРЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТАЙЛАН

### I. Эрх зүйн бичиг баримт


- ЭМС-ын 2021.09.15-ны “Журам шинэчлэн батлах тухай” А/578 тоот тушаалын дагуу үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгааг QR код үүсгэн, амбулатори, тасгуудад ил тод байрлуулж, судалгаа авч байна.

### II. 2026 ОНЫ II УЛИРАЛД АМБУЛАТОРИОР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ

1. 2026 оны II улиралд амбулаториор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны тоон үзүүлэлт:



- Тайлбар: 2026 оны II улиралд амбулаториор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг 393 үйлчлүүлэгч бөглөсөн байна.
2. Судалгаанд хамрагдагсдыг насны бүлгээр нь дүгнэн үзвэл:




- Тайлбар: Судалгааг насны бүлгээр нь дүгнэн үзвэл 20-40 насныхан нийт судалгааны 69.9%-ийг эзэлж байна.
3. 2025 оны II улиралд судалгаанд хамрагдагсдыг эмчид үзүүлэх шинжилгээ өгөх цаг авсан байдлаар нь дүгнэн үзвэл:



➤ Тайлбар: 2026 оны II улиралд 27.9% цахимаар цаг авч үйлчлүүлж байна.


**4. 2026 оны II улиралд судалгаанд хамрагдагсдын эмнэлэгт ирснээс хойш тусламж үйлчилгээ авах хүртэл хүлээгдлийг нь дүгнэн үзвэл:**



➤ Тайлбар: Үйлчлүүлэгчийг эмнэлэгт ирснээс хойш тусламж үйлчилгээ авах хүртэл хүлээгдлийг харвал өдөртөө үзүүлж тусламж үйлчилгээгээ авч чадаж байна.


**5. 2026 оны II улиралд эмнэлэг доторх өрөө, тасгийн зохион байгуулалтыг заасан тэмдэг тэмдэглэгээний ойлгомжтой эсэхийг дүгнэн үзвэл:**

## Дуугүй хөтөч, тэмдэг тэмдэглэгээ ойлгомжтой байдлыг үнэлсэн үнэлгээ




➤ Тайлбар: Эмнэлгийн дуугүй хөтөчийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд 2026 оны II улиралд нийт судалгаанд хамрагдагсдын 87.4% нь дуугүй хөтөч ойлгомжтой байна гэж дүгнэсэн байна.

### 6. Үйлчлүүлэгчийн хүлээгдлийн хэсэг тав тухтай эсэхийг үнэлэхэд:



➤ Тайлбар: Хүлээгдлийн хэсэг тав тухтай байдлыг үнэлэхэд судалгаанд хамрагдагсдын 87.4% нь сайн гэж дүгнэсэн байна.

### 7. 2026 оны II улиралд үйлчлүүлэгчийн нууцлалын түвшнийг дүгнэн үзвэл:




➤ Тайлбар: Нууцлалын түвшин 96.1% маш сайн болон сайн гэж дүгнэсэн байна.

**8. 2026 оны II улиралд орчны цэвэрлэгээ үйлчилгээг дүгнэн үзвэл:**



➤ Амбулаторийн цэвэрлэгээ үйлчилгээг 2026 оны II улиралд 88.9% нь маш сайн болон сайн гэж дүгнэсэн байна.


**9. 2026 оны II улиралд эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлагыг дүгнэн үзвэл:**



➤ Эмч эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага ёс зүйн үнэлгээнд 94.8% эмч эмнэлгийн ажилчидад сайн гэж дүгнэсэн байна.

**Амбулаториор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлт**

Эмнэлгийн тусламж үйлчилгээнд сэтгэл хангалуун байгаа эсэхийг үнэлэхэд 94% нь сэтгэл ханамж маш сайн болон сайн гэж хариулсан байна.




➤ 6% нь сэтгэл ханамж муу байна гэж хариулсан нь дараах саналыг үйлчлүүлэгч өгсөн байна.

- Ариун цэврийн өрөөний тоог нэмэх
- Бариа засалчийн тоог нэмэх
- Ус цэвэршүүлэгчтэй болох зэрэг саналууд ирсэн байна.


### **III. 2026 ОНЫ II УЛИРАЛД ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ**

**1. 2026 оны II улиралд хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны тоон үзүүлэлт:**




➤ 2026 оны II улиралд нийт 542 эмчлүүлэгч сэтгэл ханамжийн судалгааг бөглөсөн байна.

**2. 2026 оны II улиралд судалгаанд хамрагдагсдыг тасаг, нэгжүүдээр нь ангилан дүгнэн үзвэл:**




### 3. 2026 оны II улиралд судалгаанд насны бүлгээр дүгнэн үзвэл:



- Насны бүлгээр нь ангилвал 2026 оны II улиралд 20-35 насныхан хамгийн өндөр хандалттай буюу 33.6% эзэлж байгаа бол 46-55 насныхан хамгийн бага хандалттай буюу 17% эзэлж байна.

4. 2026 оны II улиралд судалгаанд хамрагдагсдыг эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхийг зөвлөснөөс хойш эмнэлэгт хэвтэх хүртэлх хүлээгдлийг дүгнэн үзвэл:




- Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхийг зөвлөснөөс хойш эмнэлэгт хэвтэх хүртэлх хүлээгдлийг дүгнэн үзэхэд 2026 оны II улиралд 81.5% 1-7 хоногт багтан хэвтэн эмчлүүлж байна.

5. 2026 оны II улиралд тасгуудын өрөөний тав тухтай байдлыг дүгнэн үзвэл:



- Өрөөний тав тухтай байдлыг үнэлэн үзвэл 2026 оны II улиралд 95% өрөө тав тухтай байна гэж үнэлсэн байна.

6. 2026 оны II улиралд байдлаар хэвтэн эмчлүүлж буй өрөө, тасалгаа зохион байгуулалтыг заасан тэмдэг тэмдэглэгээний ойлгомжтой эсэхийг дүгнэн үзвэл:




➤ Тайлбар: Тасгуудын дуугүй хөтөчийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд 2026 оны II улиралд нийт судалгаанд хамрагдагсдын 97.4% нь дуугүй хөтөч ойлгомжтой байна гэж дүгнэсэн байна.

#### 7. 2026 оны II улиралд тасгуудын цэвэрлэгээ үйлчилгээг дүгнэн үзвэл:



➤ Тайлбар: Тасгуудын цэвэрлэгээ үйлчилгээг дүгнэхэд 2026 оны II улиралд 97,3% маш сайн болон сайн гэж дүгнэсэн байна.

#### 8. 2026 оны II улиралд эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлагыг дүгнэн үзвэл:




## 9. 2026 оны II улиралд байдлаар хоолны амт чанарыг дүгнэн үзвэл:



- Эмнэлгийн хоолны амт чанарын судалгааг дүгнэхэд 2026 оны II улиралд 88% сайн гэж дүгнэсэн нь хоолны амт чанар, хүртээмж сайжирч буйг илтгэж байна.

### Хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлт

Эмнэлгийн тусламж үйлчилгээнд сэтгэл хангалуун байгаа эсэхийг үнэлэхэд 97% нь сэтгэл ханамж маш сайн болон сайн гэж хариулсан байна.



- 3% нь сэтгэл ханамж муу байна гэж хариулсан нь дараах саналыг үйлчүүлэгч өгсөн байна.
- Хоолны төрөл нэмэх
  - Эм тарианы нөөцийг сайжруулах санал ирсэн байна.

## Дүгнэлт:

1. 2026 оны II улиралд Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвөөс амбулатори болон хэвтэн эмчлүүлэгчдийн дунд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр зохион байгуулж, нийт 935 үйлчлүүлэгчийг хамрууллаа. Судалгааны дүнгээр үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 95.5% гарсан нь тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, ажилтнуудын харилцаа хандлага болон үйл ажиллагааны зохион байгуулалт үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, хүлээлтэд нийцэж байгааг харуулж байна.
2. Судалгааны үр дүнгээр амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 94%, хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж 97% үнэлэгдэж эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, үйлчлүүлэгчийн нууцлал, орчны цэвэрлэгээ, тав тухтай байдалд эерэг үнэлгээ өгсөн байна. Түүнчлэн үйлчлүүлэгчдийн дийлэнх нь тусламж үйлчилгээг цаг алдалгүй авч, эмнэлгийн зохион байгуулалт, тэмдэг тэмдэглэгээ ойлгомжтой байгааг үнэлжээ.
3. Судалгаанд оролцогчдоос ариун цэврийн өрөөний хүртээмжийг нэмэгдүүлэх, бариа заслын үйлчилгээний хүчин чадлыг сайжруулах, ус цэвэршүүлэгчийг нэмэгдүүлэх, хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх, эм тарианы нөөцийг сайжруулах зэрэг санал хүсэлт ирсэн байна.
4. Нийт дүнгээр үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж өндөр түвшинд үнэлэгдсэн нь байгууллага үйлчлүүлэгч төвтэй, чанартай, аюулгүй тусламж үйлчилгээг тогтвортой үзүүлж байгааг харуулж байна.

ТАЙЛАН БИЧСЭН

ЛММ

Ц.БАТДАЛАЙ